



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

322.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 134	1390
323.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 135	1390
324.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 136	1391
325.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 137	1391
326.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 138	1392
327.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 139	1392
328.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 141	1393

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

329.	Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам батлах тухай	Дугаар 200	1393
330.	Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах тухай	Дугаар 212	1398
331.	Журам батлах тухай	Дугаар 221	1402
332.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 223	1408



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 08 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 134

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Тэрбишийн Чимэддоржийг эгүүлэн татаж, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чимиддоржийн Баттөмөрийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 08 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Данийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Балдангийн Энхмандахыг эгүүлэн татаж, Данийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Зоригийн Алтайг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 08 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Эстони Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Эстони Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Зоригийн Алтайг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 08 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Тажикистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хараавчийн Аюурзаныг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Тажикистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагирын Сүхээг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 08 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Киргиз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хараавчийн Аюурзаныг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Киргиз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Жагирын Сүхээг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 08 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Израйль Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Очирын Очиржавыг эгүүлэн татаж, Израйль Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Булгаагийн Алтангэрэлийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 08 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Долоонжингийн Идэвхтэнг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шүхэрийн Алтангэрэлийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 5 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 200

Улаанбаатар  
хот

### Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам батлах тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Орон сууцны зээлийн хөнгөлөлтөд хамрах зорилтот бүлэгт үзүүлэх хөнгөлөлтийг тодорхойлох, хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаар тодорхой санал боловсруулан энэ оны 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт тус тус даалгасугай.

3. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа, түүний тэмдэглэлийн агуулга, тэмдэглэл хийх журмыг хамтран батлахыг Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд



даалгаж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.

4. Тусгай зөвшөөрөлтэй компани, түүнийг үүсгэн байгуулахтай холбогдсон харилцаа болон үнэт цаас, түүний барьцаа хөрөнгийн бүртгэлтэй холбогдсон харилцааг шинэчлэх арга хэмжээ авахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.

5. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-ыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарт тус тус даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Ц.БАЯРСАЙХАН**

Засгийн газрын 2013 оны 200 дугаар  
тогтоолын хавсралт

**ОРОН СУУЦНЫ ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 135 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын иргэд (цаашид “Зээлдэгч” гэх)-д олгох орон сууцны ипотекийн зээлийн нөхцөлийг тогтооход оршино.

1.2. Энэ журмаар олгох ипотекийн зээлийг Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг ханган ажиллаж буй банкаар дамжуулан олгоно.

1.3. Энэ журмын дагуу инженерийн дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус, ариутгах татуурга, холбоо дохиолол)-д бүрэн холбогдсон, эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтад хүлээн авсан шинэ орон сууц (цаашид “шинэ орон сууц” гэх) болон инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын



шийдвэрээр ашиглахыг хориглоогүй, ашиглагдаж байгаа хуучин орон сууц (цаашид “хуучин орон сууц” гэх) худалдан авах хүсэлтэй Монгол Улсын иргэдэд орон сууцны ипотекийн зээлийг олгоно.

1.4. Энэ журмын дагуу олгох ипотекийн зээлийн үйл ажиллагаа нь Монголбанкнаас баталсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам” болон тухайн банкны энэ журамд нийцүүлэн баталсан зээлийн үйл ажиллагааны журмын дагуу хэрэгжинэ.

1.5. Энэхүү журам нь Ипотекийн санхүүжилтийн тогтолцооны бүрдэл хэсэг болно.

#### Хоёр. Зээлийн ерөнхий нөхцөл

2.1. Зээлээр худалдан авах орон сууцны нийт талбайн хэмжээ нь 80 м<sup>2</sup>-аас дээшгүй байх бөгөөд шинэ орон сууцны нийт талбайн хэмжээг “Орон сууцны барилгын доторхи сууцны талбай тооцох аргачлал” MNS 6058:2009 стандартын дагуу тооцно.

2.2. Ипотекийн зээлийн хугацаа нь 20 хүртэл жил байна.

2.3. Ипотекийн зээлийн хүү жилийн 8 (±1) хувь байх бөгөөд жилийн инфляциас хамаарч өөрчлөгдөж болно. Ипотекийн зээлийн хүү нь Засгийн газар, Монголбанк хооронд байгуулсан “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах санамж бичиг”-ийн хүрээнд батлах “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох журам”-ын дагуу тодорхойлогдоно.

2.4. Орон сууцны урьдчилгаа төлбөрийн хэмжээ орон сууцны үнийн дүнгийн 10-30 хувь хүртэл байна. Зорилтот бүлэгт үзүүлэх урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээний хөнгөлөлтийн нөхцөлийг Засгийн газар тусгайлан тодорхойлно.

2.5. Зээлдэгч өөрийн өмчлөлд байгаа хуучин орон сууцаа барьцаалан зээл авч, энэ журмын дагуу олгох орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг төлж болно.

2.6. Зээлдэгчийн өр, орлогын харьцаа нь Монголбанкнаас баталсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-д зааснаар татварын өмнөх орлогын 45 хувиас ихгүй байна.

2.7. Зээлийн барьцаа нь энэ журмын 2.5-д заасан хуучин орон сууц болон энэ журмын дагуу олгосон зээлээр худалдан авах орон сууц байна.



2.8. Зээлдэгч орон сууцны ипотекийн зээлийн гэрээний хугацаа дуусахаас өмнө урьдчилан бүрэн төлж болно.

2.9. Энэ журмаар олгох зээл нь бүрэн хорогдох, тогтмол хүүтэй зээл байна.

2.10. Өмнө нь олгосон орон сууцны ипотекийн зээлийг энэ журмын дагуу олгох орон сууцны ипотекийн зээлд шилжүүлж, зээлийн дахин санхүүжилт хийж болно.

2.11. Банк зээлийн дахин санхүүжилт хийхдээ дараахь зарчмыг баримтална:

2.11.1. дахин санхүүжилтийн хэмжээ өмнөх орон сууцны ипотекийн зээлийн өрийн үлдэгдлээс ихгүй байх;

2.11.2. дахин санхүүжилт хүсэгч зээлдэгч нь зээлийн нөхцөлийн болон зээлдэгчийн шалгуур, барьцаа хөрөнгийн шалгуурыг тус тус хангасан байх;

2.11.3. дахин санхүүжилт хүсэгч зээлдэгч нь сүүлийн 6 сарын хугацаанд зээлийн сайн түүхтэй, зээлийн эргэн төлөлт нь хэвийн ангилалд байх;

2.11.4. дахин санхүүжилтээр олгож байгаа орон сууцны ипотекийн зээл нь бүрэн хорогдох, тогтмол хүүтэй байх.

2.12. Энэ журмын 3.1.3, 3.1.4-т заасны дагуу олгосон орон сууцны ипотекийн зээлийн өрийн үлдэгдлийг энэ журмын дагуу олгох зээлийн эх үүсвэрээр дахин санхүүжүүлэхгүй.

2.13. Нийтийн зориулалттай орон сууцны ипотекийн зээлээс бусад ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэхгүй.

Гурав. Зээлдэгчид тавих шалгуур үзүүлэлт

3.1. Энэ журмын дагуу орон сууцны ипотекийн зээл авах хүсэлт гаргаж байгаа иргэн дараахь шаардлагыг хангасан байна:

3.1.1. Монгол Улсын иргэн, 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай байх;

3.1.2. банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өргүй, шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр, төлбөргүй байх;





3.1.3. өрхийн<sup>1</sup> гишүүний аль нэг нь Засгийн газрын 2009 оны 368 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах журам”-ын дагуу авсан орон сууцны ипотекийн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

3.1.4. өрхийн<sup>1</sup> гишүүний аль нэг нь Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд (хуучнаар), Сангийн сайд, Нийслэлийн Засаг даргын 2012 оны 45/49/А-108 дугаар хамтарсан тушаал, захирамжаар баталсан “Иргэдийг жилийн 6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах харилцааг зохицуулах журам”-ын дагуу авсан орон сууцны ипотекийн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

3.1.5. барьцаалбар үйлдсэн байх.

3.2. Энэ журмын дагуу олгох ипотекийн зээлийн барьцаа болох орон сууц нь дараахь шаардлагыг хангасан байна:

3.2.1. Монгол Улсад байршилтай, зөвхөн нийтийн зориулалттай орон сууц байх;

3.2.2. нийт талбай нь 80 м<sup>2</sup>-аас дээшгүй орон сууц байх;

3.2.3. инженерийн дэд бүтэц бүрэн холбогдсон, эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтад хүлээн авсан шинэ орон сууц байх;

3.2.4. инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, барилгын техникийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын шийдвэрээр ашиглахыг хориглоогүй, ашиглагдаж байгаа хуучин орон сууц байх;

3.2.5. Монголбанкнаас баталсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу хөрөнгийн болон амь насны даатгалд хамрагдсан байх;

3.2.6. эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтад хүлээн авсан, эд хөрөнгө өмчлөх болон эд хөрөнгийн бусад эрхийн талаар гуравдагч этгээдэд шаардах эрх үүсээгүй байх;

3.2.7. банк ипотекийн зээлийн барьцаа болж байгаа орон сууцны чанар, ашиглалтын байдал, барьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөлтэй холбоотой нэмэлт шаардлага тавих эрхтэй байна.

<sup>1</sup>Өрх гэж хуулийн дагуу гэрлэлтээ баталгаажуулсан эхнэр, нөхөр эсхүл орон сууцны ипотекийн зээлийн өр, орлогын харьцаа тооцоход орлого нь хамрагдсан, орон сууцны зээлийн барьцаа хөрөнгийн хамтран эзэмшигчээр бүртгэгдсэн этгээдүүдийг хэлнэ.



Дөрөв. Бусад

4.1. Энэ журмын хэрэгжилтэд орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эдийн засаг, хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, сангийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тус тус хяналт тавьж ажиллана.

4.2. Энэ журмын заалттай холбоотой маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.3. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2013 оны 6 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар  
хот

**Төрийн байгууллагуудын цахим  
мэдээллийн санг ашиглах тухай**

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.8, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 22.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаа, Тагнуулын ерөнхий газрын дарга Б.Ариунсан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.САЙХАНБИЛЭГ**

Засгийн газрын 2013 оны 212 дугаар  
тогтоолын хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ  
МЭДЭЭЛЛИЙН САНГ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Төрийн байгууллагын цахим мэдээллийн сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, цахим мэдээлэл солилцох, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээтэй холбогдсон мэдээллийг шуурхай, нэг цэгээс үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад байршиж байгаа цахим бүртгэл, мэдээллийн санг “Үндэсний Дата төв” УТҮГ болон Тагнуулын ерөнхий газрын дэд бүтэцтэй холбон байршуулж, төрийн байгууллагуудын болон салбар хоорондын цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох системийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Цахим мэдээлэл солилцох систем нь төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад бүрдсэн цахим бүртгэл, мэдээллийн сан, нэгдсэн сан тэдгээрийг ашиглан мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, технологи, шийдэл, мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн төрийн мэдээлэл, холбооны системд хамаарах мэдээллийн цахим үйлчилгээ, сүлжээний дэд систем байна.

1.3. Цахим мэдээлэл солилцох системийг дараахь чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор ашиглана:

1.3.1. цахим мэдээлэл солилцох системд холбогдсон байгууллагууд хоорондын мэдээллийн солилцоог нэгдсэн зохицуулалтаар хангах;

1.3.2. цахим мэдээлэл солилцох системээс иргэн, албан байгууллага зохих журмын дагуу мэдээлэл авах, ашиглах боломжийг бүрдүүлж Засгийн газрын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгоход дэмжлэг үзүүлэх;

1.3.3. цахим мэдээллийн санг байршуулах, хадгалах, нийтэд хүртээмжтэй болгох үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг баримтлан ажиллах.

1.4. Цахим мэдээлэл солилцох системийг байгуулахдаа дараахь шаардлагыг хангасан байна:



1.4.1. иргэн, албан байгууллагын цахим мэдээлэл солилцох системээр дамжуулан авч байгаа мэдээлэл нь үнэн зөв, бодит мэдээлэл байх;

1.4.2. цахим мэдээлэл солилцох системд холбогдсон мэдээллийн системүүд нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн журмын дагуух техникийн нөхцөлийг бүрдүүлсэн байх;

1.4.3. цахим мэдээлэл солилцох систем цахим халдлага, мэдээлэл алдагдахаас хамгаалагдсан байх;

1.4.4. цахим мэдээлэл солилцооны үйл ажиллагаа, үйлчилгээний талаар цахим бүртгэл хөтлөх;

1.4.5. төрийн цахим мэдээллийн сангийн төрийн нууцад хамаарах цахим бүртгэл, мэдээллийн сангуудыг ашиглах, хадгалахтай холбогдсон үйл ажиллагааны үе шат бүрт мэдээллийн нууцлалыг хангах, халдлагаас хамгаалах, техник, программ хангамжийн арга хэмжээг цогцоор авч хэрэгжүүлэх.

#### Хоёр. Төрийн цахим мэдээллийн сангийн ашиглалт үйлчилгээ

2.1. Төрийн байгууллагууд хоорондоо цахим мэдээлэл солилцохдоо “Үндэсний дата төв” УТҮГ болон Тагнуулын ерөнхий газарт байрших цахим мэдээлэл солилцох системийг ашиглана. Цахим мэдээлэл солилцох систем нь төвлөрсөн мэдээллийн санг ашиглана.

2.2. “Үндэсний дата төв” УТҮГ нь төвлөрсөн цахим мэдээллийн санг ашиглах тухай тухайн байгууллагуудын хооронд гэрээ байгуулан мэдээлэл солилцох системтэй холбож, холбогдох техникийн нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.

2.3. Цахим мэдээллийн санг баяжуулах, мэдээлэл солилцооны системд холбогдоход тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг “Үндэсний дата төв” УТҮГ боловсруулан баталгаажуулж, үйл ажиллагаа, техникийн шийдэлд Тагнуулын ерөнхий газар хяналт тавина.

2.4. Төрийн мэдээллийн сангийн ашиглалт үйлчилгээний талаархи гэрээнд цахим мэдээллийн сангийн баяжуулалт, шинэчлэлт хийх хугацааны давтамж, ашиглах мэдээллийн жагсаалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгана.



2.5. Цахим мэдээллийн санг ашиглуулах гэрээний дагуу хийсэн боловсруулалт, ашиглалтад тавих хяналтыг уг асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийж гүйцэтгэнэ.

Гурав. Цахим мэдээллийн сангийн үйл  
ажиллагааг зохицуулах

3.1.Төрийн цахим мэдээлэл солилцох системд ашиглагдах сүлжээ, программ хангамжийн техникийн нөхцөлийг “Үндэсний дата төв” УТҮГ боловсруулан хөгжүүлэх бөгөөд тус системд холбогдон ажиллах системийн шийдэлд дараахь төрлийн зөвшөөрлийг “Үндэсний дата төв” УТҮГ зохих журмын дагуу олгоно. Үүнд:

3.1.1. цахим мэдээллийн санг дамжуулахад ашиглах сүлжээ, холбогдох программ хангамжийн шийдлийг ашиглах;

3.1.2. төрийн цахим мэдээлэл солилцох системтэй ажиллах программ хангамжийг ашиглах, суурилуулах, хөгжүүлэх зөвшөөрөл.

3.2. Төрийн цахим мэдээлэл солилцох системд хэрэглэгдэх нууцлал, хамгаалалтын техникийн нөхцөлийг боловсруулан ашиглах дараахь төрлийн зөвшөөрлийг Тагнуулын ерөнхий газраас олгоно. Үүнд:

3.2.1. цахим мэдээллийн санг ашиглахад хэрэглэгдэх нууцлал, шифрлэлтийн талаар шийдэлд олгох зөвшөөрөл;

3.2.2. цахим мэдээллийн санг ашиглах эрхийн зөвшөөрөл.

3.3. Төрийн цахим мэдээллийн нэгдсэн сангийн болон цахим мэдээлэл солилцооны холбогдох сервер, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний талаархи бусад асуудлууд “Үндэсний Дата төв” УТҮГ болон тухайн байгууллага хооронд байгуулсан үйлчилгээний гэрээгээр зохицуулагдана.

Дөрөв. Талуудын хүлээх үүрэг хариуцлага

4.1. Тагнуулын ерөнхий газар, “Үндэсний Дата төв” УТҮГ нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа цахим мэдээллийг хамгаалах талаархи холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн цахим мэдээллийн системийг нэгдсэн зохицуулалтаар хангаж ажиллана.

4.2. “Үндэсний Дата төв” УТҮГ нь төрийн цахим мэдээллийн системийн дэд бүтцийн хэвийн, найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллана.



4.3. Төрийн цахим мэдээллийн сангийн үйлчилгээнд ашиглагдах мэдээллийг шифрлэх, нууцлах арга хэрэгслийг Улсын шифрийн төв алба боловсруулан хэрэгжүүлнэ.

4.4. Мэдээлэл солилцох системд холбогдсон байгууллагуудын системийн ашиглалт, мэдээлэл солилцох системийн үйл ажиллагаанд Тагнуулын ерөнхий газар хяналт тавина.

4.5. “Үндэсний Дата төв” УТҮГ нь төрийн цахим мэдээллийн системд тухайн байгууллагуудыг холбох, үйлчилгээнд бэлтгэх, үйлчилгээг нээх, шинэчлэх, хөгжүүлэх, зогсоох, хаах зорилгоор холбогдох үйл ажиллагааг төлөвлөж ажиллана.

4.6. Төрийн цахим мэдээллийн санг байршуулж байгаа байгууллага нь холбогдох гэрээний дагуу ашиглах мэдээллийн сан, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

4.7. Цахим мэдээллийн санг ашиглах явцад мэдээлэл алдагдах, устгах зэрэг нөхцөл байдал үүсэхэд буруутай тал нь хариуцлага хүлээнэ.

4.8. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 6 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Улсын шилдэг хоршоо шалгаруулах журам”-ыг хавсралт ёсоор баталж 2013 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Улсын шилдэг хоршоог шагнахад шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Я.САНЖМЯТАВ**



Засгийн газрын 2013 оны 221 дүгээр  
тогтоолын хавсралт

УЛСЫН ШИЛДЭГ ХОРШОО ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Засгийн газрын 2009 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн хоршоологчдын нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг өсгөхөд дэмжлэг үзүүлэх үүднээс шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Хоршооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага “Улсын шилдэг хоршоо”-г жил бүр шалгаруулж урамшуулна.

3. Улсын шилдэг хоршоог шалгаруулах ажиллагаа нь ил тод, нээлттэй, шударга байх зарчимд суурилна.

Хоёр. Шалгуур үзүүлэлт

4. “Олон Улсын Манчестрийн Их Хурлаас гаргасан Хоршооллын хөдөлгөөний 21-р зуунд баримтлах үндсэн 7 зарчмын (Хадгаламж зээлийн хоршооны хувьд 9 зарчим) хэрэгжилтийг хангаж, хоршооны тогтвортой хөгжлийг бүрдүүлж, амжилт гаргасан дараах шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан хоршоог “Улсын шилдэг хоршоо”-гоор шалгаруулахаар тодорхойлно:

4.1. Монгол Улсын Хоршооны тухай хууль болон холбогдох хууль, эрх зүйн актыг мөрдсөн байх;

4.2. Гишүүдийн тооны өсөлт жилд 5%-иас доошгүй байх;

4.3. Нийт активын өсөлт нь тухай жилийн инфляцийн түвшнээс багагүй байх;

4.4. Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тоо болон чанарын хувьд өссөн байх;

4.5. Олон улсын “Сайн засаглал”-ын зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог байх;

4.6. Орон нутгийнхаа нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг байхаас гадна сайн танигдсан брэнд бүтээгдэхүүнтэй байх;



4.7. Хоршооны үйл ажиллагаа нь тогтмолжиж, өөрийн байр суурийг эзэлсэн түүхий эдийн хангалт, үйлдвэрлэлт, борлуулалтын тогтсон сүлжээтэй байх;

4.8 Хадгаламж зээлийн хоршоо нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ханган ажилласан байх;

4.9. Улсын болон бүсийн үзэсгэлэн, худалдаанд амжилттай оролцсон байх;

4.10. Шинээр бий болж буй хоршоод болон бүлэг, иргэдийг хоршоо болоход нь дэмжлэг үзүүлэх, туршлага судлах, үзүүлэх сургалтуудыг зохион байгуулсан байх;

4.11. Санхүүгийн гол харьцаа үзүүлэлтүүдийг ханган ажилладаг байх;

4.12. Нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн стандарт мөрдөж ажилласан байх;

4.13. Холбогдох хууль, тогтоомжийн дагуу татвар, хураамжийг хугацаанд нь бүрэн төлсөн, хугацаа хэтэрсэн зээлгүй байна.

5. Шилдэг хоршоо мөн болохыг орон нутгийн хоршооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо болон мэргэжлийн холбоо, Санхүүгийн зохицуулах хороо баталгаажуулсан байна.

#### Гурав. Шалгаруулах ажиллагаа, шагнал олгох

6. Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо хоршоодын ажлын үзүүлэлтэд үндэслэн “Улсын шилдэг хоршоо”-нд нэр дэвшигдсэн хоршоог дэмжин шалгуур хангасан материал бүрдүүлэх, шалгаруулалт хийх эрх бүхий байгууллагад санал хүргэх ажлыг хариуцан зохион байгуулна.

7. Улсын шилдэг хоршоог шалгаруулах саналыг Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны хурлаас гаргаж, эрх бүхий байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.





8. Хоршооллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь улсын шилдэг хоршооны материалыг хянан үзэж таваас доошгүй хоршоог шалгаруулна.

9. Хоршоог “Улсын шилдэг хоршоо”-гоор зөвхөн нэг удаа шагнана.

10. Улсын шилдэг хоршоогоор шалгарсан хоршоонд “Улсын шилдэг хоршоо”-ны хүндэт өргөмжлөл, дурсгалын хаяг гардуулж, мөнгөн шагналыг дагалдуулна.

11. Шагналыг жил бүр Олон улсын болон Үндэсний хоршооллын өдрийг тохиолдуулан Засгийн газрын төлөөлөгч гардуулна.

“Улсын шилдэг хоршоо шалгаруулах  
журам”-ын хавсралт

“УЛСЫН ШИЛДЭГ ХОРШОО”-НД ТОДОРХОЙЛЖ БАЙГАА  
..... АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН .....  
СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ..... ХОРШООНЫ  
ТОДОРХОЙЛОЛТ

Нэг. Хоршооны хөдөлгөөний баримтлах үндсэн  
7 зарчмын биелэлт

1. Хоршооны нэр, үйл ажиллагааны чиглэл, байгуулагдсан он

.....  
.....

2. Тодорхойлогдож байгаа Хоршооны засаглалын нэгж (Бүх гишүүдийн хурал, Тэргүүлэгч, Хяналтын зөвлөл, Гүйцэтгэх алба)-үүдийн үйл ажиллагааны жилийн тайлан:

.....



3. Бүх гишүүдийн хурал хийсэн эсэх, хэлэлцсэн асуудлууд

.....  
4. Гишүүдийн тоо

.....  
5. Ажлын байрны тоо (Нийт ажилчид болон улирлын гэрээт ажилчдын тоо)

.....  
6. Хүний нөөцийн чадавхижуулалт (Хоршооны гишүүд, ажилчдын мэргэжил, ур чадвар, гишүүдэд сургалт зохион байгуулсан эсэх, явуулсан сургалтуудын сэдэв, бүсчилсэн сургалтуудад оролцсон эсэх, туршлага судалсан байдал, оролцогсдын тоо)

.....  
7. Гишүүнчлэлийн талаарх мэдээлэл (Аль холбооны гишүүн, хэдэн онд элссэн)

.....  
8. Хоршооны хамтын ажиллагаа (Хоршоо болон аж ахуйн нэгжүүд (нөхөрлөл, компани) өрх бүл, бүлгүүдтэй хэрхэн хамтран ажилладаг тухай)

.....  
9. Хоршооны тогтвортой хөгжлийн байдал

.....  
10. Хоршооны бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо



11. Орон нутгийнхаа нийгмийн хөгжилд оруулсан хувь нэмэр

.....

12. Орон нутгийн болон аймаг, нийслэлийн ямар байгууллагуудтай хамтран ажилладаг (Улсын болон бүсийн зөвлөгөөн, семинар, үзэсгэлэн яармаг)

.....

Хоёр. Санхүүгийн үзүүлэлт (Сүүлийн 5 жилээр)

13. Нийт актив хөрөнгө (мян.төг)

.....

14. Хоршоонд хэдэн гишүүн хэдээс хэдэн төгрөгийн хөрөнгө хувь нийлүүлсэн (мян.төг)

.....

15. Хоршооны бүтээгдэхүүн борлуулалт

.....

Гурав. Шагнал урамшуулал

16. Аймаг, нийслэл, дүүргийн тэргүүний хоршоогоор буюу аж ахуйн нэгжээр, улсын болон бүсийн, аймаг, нийслэлийн үзэсгэлэнд оролцож хэдэн онд шалгарч байсан.

.....

17. Хоршооны бүтээгдэхүүн, үйл ажиллагааны зурган танилцуулга DVD, CD дээр бичсэн видео кино.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 6 дугаар  
ёарын 22-ны өдөр

Дугаар 223

Улаанбаатар  
хот

### Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолын хавсралтад дараах заалтыг нэмсүгэй:

“9.1.9. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх этгээдэд тусгай зөвшөөрөл олгоход 500.000 төгрөг”.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**САНГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 14003